- Автомашины тусгай төхөөрөмж ажиллуулах нормыг хянан үндсэн норм болгон мөрдөх, гүйлтийн нормоор шатахуун зарцуулалтыг тооцох боломжгүй технологийн тээвэр гүйцэтгэж буй автомашины шатахуун зарцуулалтын нормыг ажлын зураг авалт хийж 1 цагт олгох шатахууны хэмжээг тогтоон мото.цагаар олгож болно.
- Автомашинаас цахилгааны эх үүсвэр авах, өвлийн улиралд автомашиныг халаах гэх мэт зориулалтаар хөдөлгүүрийг ажиллуулахад 100 км гүйлтэд зарцуулах үндсэн нормын 5 %-иар бодож олгоно.

### 3. Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох аргачлал, зөвлөмж

Автотээвэрт хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шатахуун, тосолгооны материалыг зохистой зарцуулах, техникийн үндэслэлтэй, үнэн зөв норм тогтоож мөрдөх, урамшууллын механизм хэрэглэх явдал нэн чухал ач холбогдолтой.

Автотээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага иргэд шатахуун зарцуулалтын нэгж, байгууллага, иргэд шатахуун зарцуулалтын нэгжийн норм, хэрэгцээг төлөвлөж тодорхойлох, автомашины шатахуун зарцуулалтын нормыг өөрсдөө тогтоох, шатахуун зарцуулалтын нормыг нэмэгдүүлэх ба хорогдуулах, хэмжилт сорилт хийхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад зориулагдана.

Автотээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын норм тооцох аргачлал:

- Автотээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллаг иргэд нь автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг автомашины 100 км гүйлтэд зарцуулах жишиг нормыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.
- Шатахуун зарцуулалтын жишиг нормыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд боломжтой гэж үзвэл үндсэн нормоор нь шууд мөрдөх, эсвэл тодорхой хугацаанд уг жишиг нормын мөрдөлтөд хэмжилт, судалгаа явуулсны үндсэн дээр өөрийн ажил, үйлчилгээний онцлог, автозамын болон цаг агаарын нөхцөл байдалтайгаа нийцүүлэн нэмэгдүүлэх юмуу хорогдуулах замаар үндсэн норм болгож хэрэглэж болно.
- Шатахуун зарцуулалтын жишиг норм тогтоогдоогүй марк загварын хувьд шатахуун зарцуулалтын жишиг нормыг тухайн автомашины үйлдвэрлэгчийн тогтоосон шатахуун зарцуулалтын хяналтын нормын болон ашиглалтын нөхцлөөс хамаарч хяналтын зарцуулалтын өөрчлөлтийн хэмжээг илэрхийлэх коэффициентийн тусламжтайгаар тооцооны аргаар тогтоож болно.
  - Автомашины шатахуун зарцуулалтыг (л/100 км) үйлдвэрлэгч фирм тогтоож тухайн автомашины техникийн тодорхойлолт, ашиглалтын зааварт тусгасан байдаг.
  - Автомашины шатахуун зарцуулалтыг ашиглалтын нөхцлөөс хамааруулан өсгөх коэффициентийг  $K_{\theta}$  судалгаагаар тогтооно.
  - Энэхүү коэффициент нь ачаа, суудлын зориулалтын ердийн автомашинд 1,2, туулах чадварыг нэмэгдүүлсэн автомашинд 1,1 байна.

Автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг хяналтын зарцуулалтыг өсгөх коэффициентийн тусламжтайгаар дараах томъёог ашиглан тодорхойлно.

$$N_{\text{жишиг}} = N_{\text{хяналт}} \times K_{\theta}$$

Энд:

$N_{\text{жишиг}}$  – Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм

$N_{\text{хяналт}}$  – Шатахуун зарцуулалтын хяналтын норм, л/100 км

$K_{\text{ө}}$  – Шатахуун зарцуулалтын хяналтын нормыг ашиглалтын нөхцлөөс хамааруулан өсгөх коэффициент.

Энэ аргаар тогтоосон жишиг норм нь шатахууны бодит зарцуулалтын баримжаа хэмжээг харуулах бөгөөд судалгааны статистикийн болон сорилтын аргаар хэмжилт хийж баталгаажуулах зайлшгүй шаардлагатай болно.

- Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хэмнэсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан тогтоосон нормоос шатахуун хэмнэсэн жолоочид хэмнэлтийн тодорхой хувиар шагнал олгох юмуу бусад урамшуулал үзүүлж болно. Энэхүү шагнал урамшуулал олгох журмыг тухайн аж ахуйн нэгж, байгууллаг тогтооно.

Автомашины шатахуун зарцуулалтын нормын төрлүүд:

- Автомашины шатахуун зарцуулалтын норм нь нэгжийн болон автотээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын үндсэн норм гэсэн хоёр бүлэг нормоос бүрдэнэ. Шатахуун зарцуулалтын нэгж ажлын нормыг нийт зарцуулсан шатахууныг нийт гүйцэтгэсэн ажлын хэмжээнд хувааж тодорхойлох бөгөөд дараах нэгжээр тодорхойлно. Үүнд:
  - ачаа тээврийн ажилд гр/тн.км
  - зорчигч тээврийн ажилд гр/зорчигч.км
  - такси тээврийн ажилд гр/төл.км
  - цагийн тээврийн үйлчилгээнд гр/төл.цаг
- Шатахууны нэгж зарцуулалтын нормыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж, салбар улсын хэмжээгээр шатахууны хэрэгцээг тээвэрлэлтийн ажлын хэмжээнээс хамааруулан төлөвлөх, шатахуун зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийх, хэмнэлтийн хэмжээг тодорхойлох, салбаруудын хоорондын шатахуун зарцуулалтын байдлыг харьцуулан үнэлэх зэрэгт ашиглана.
- Автомашины шатахуун зарцуулалтын хэмжээ нь дараах үндсэн норм, нэмэгдлүүдээс бүрдэнэ. Үүнд:
  - а. Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны үндсэн норм:
    - Ачаа, тээврийн автомашины ачаагүй явсан 100 км гүйлтэд зарцуулах шатахууны хэмжээ л/100 км
    - Суудлын автомашины, автобусны дундаж ачаалалтай үеийн 100 км гүйлтэд зарцуулах шатахууны хэмжээ л/100 км
    - Тусгай зориулалтын автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны хэмжээ л/100 км
  - б. Энэхүү тушаалын ачаа тээврийн автомашины 100 тн.км тээврийн ажил гүйцэтгэхэд зарцуулах шатахууны нормыг тооцно.

в. Автомашины ашиглалтын нөхцлөөс хамааруулан олгох шатахуун зарцуулалтын үндсэн нормын нэмэгдлүүд. Үүнд:

- Автозамын нөхцлийн нэмэгдэл /Ашиглалтын бүсийн нэмэгдэл/  
 $K_3$  %
- Хүйтний улирлын нэмэгдэл  $K_x$  %
- Тээврийн ажил үйлчилгээний онцлогийг тусгасан нэмэгдлүүд  $K_T$  %

## Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох аргачлал, зөвлөмж

№	Үзүүлэлт	Томъёо, тодорхойлолт	Зөвлөмж, тайлбар, жишээ
1	Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны жишиг норм /Н <sub>жишиг</sub> /-ыг тооцох	$N_{\text{жишиг}} = N_{\text{хяналт}} \times K_{\text{е}}$ <p>Н<sub>жишиг</sub> – Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм</p> <p>Н<sub>хяналт</sub> – Шатахуун зарцуулалтын хяналтын норм, л/100 км</p> <p>К<sub>е</sub> – Шатахуун зарцуулалтын хяналтын нормыг ашиглалтын нөхцлөөс хамааруулан өсгөх коэффициент.</p>	<p>Автомашины шатахуун зарцуулалтын хяналтын нормыг монгол орны ашиглалтын нөхцөлийг тусгасан өсгөх коэффициентийн тусламжтайгаар дараах томъёог ашиглан тодорхойлно.</p> <p>Энэхүү коэффициент нь ачаа, суудлын зориулалтын ердийн автомашинд 1,2, туулах чадварыг нэмэгдүүлсэн автомашинд 1,1 байна.</p> <p>Жишиг норм нь шатахууны бодит зарцуулалтын баримжаа болох бөгөөд статистик болон сорил, туршилтын аргаар хэмжилт хийж батлгаажуулах зайлшгүй шаардлагатай. Toyota ractis суудлын автомашины техникийн үзүүлэлтэд хяналтын зарцуулалт 100 км гүйлтэд – 5,5 л гэж заасан байна.</p> <p>Томъёогоор жишиг нормыг тооцвол:</p> $N_{\text{жишиг}} = 5,5 \text{ л} \times 1,2 = 6,6$ $N_{\text{жишиг}} \approx 6,5 \text{ л}$ <p>/Жишиг нормд ороогүй автомашиныг энэхүү томъёогоор тооцно/</p>
2	Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны үндсэн норм /N <sub>v</sub> /-ыг тооцох	<p>Автомашины 100 км сул гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтыг үндсэн норм гэнэ.</p>	<p>Автомашины техникийн байдал хэвийн үед /шатахуун зарцуулалтад нөлөөлөх техникийн гэмтэл байгаа эсэхийг тодорхойлсон байна/ тодорхой хугацааны шатахуун зарцуулалтын статистик судалгаа эсвэл шатахуун зарцуулалтын туршилт, хэмжилтээр гарсан шатахууны хэмжээг жишиг нормтой харьцуулан автомашины үндсэн нормыг тогтооно.</p> <p>Дээрх судалгааны аргыг дангаар буюу хосолмол байдлаар хэрэглэж шатахуун зарцуулалтын бодит хэмжээг тогтоож болно.</p> <p>Жишиг нормоос үндсэн норм нь бага зэргийн зөрүүтэй байж болох бөгөөд судалгаагаар гарсан буюу бодит зарцуулалтыг үндсэн норм болгон мөрдөнө.-</p> <p>Toyota ractis суудлын автомашины үндсэн нормыг тооцвол: Автомашины техникийн байдлыг шалгах /Техникийн байдал хэвийн үед судалгааг хийнэ/</p> <p>1-рт <b>статистик аргаар</b> судалсан байдал: Судалгаа хийсэн хугацаа: 1 дүгээр сарын 15-наас 3 дугаар сарын 15</p> <p>Судалгаа явагдсан байршил: Автомашин Улаанбаатар хотын замд ажилласан Судалгааны арга: Автомашины өдрийн гүйлтийг бүртгэх, цэнэглэсэн шатахууны хэмжээ, хугацааг бүртгэх.</p> <p>Бодит зарцуулалтыг тооцсон байдал: Судалгааны өгөгдлөөр бодит зарцуулалтыг тооцоход ашиглалтын нэмэгдэл буюу өвлийн нэмэгдэл, Улаанбаатар хотын хөдөлгөөний эрчимын нэмэгдлийг хасан тооцоход 100 км гүйлтэд 7,3 л шатахуун зарцуулсан тооцоо гарсан.</p> <p>Toyota ractis автомашин <math>N_{\text{жишиг}} \approx 6,5 \text{ л}</math></p> <p>Бодит зарцуулалт нь 7,3 л буюу 0,8 л-ээр зөрүүтэй байна. Иймд үндсэн нормыг</p> <p>Toyota ractis автомашины үндсэн нормыг <math>N_v \approx 7.5 \text{ л}</math> тогтоож мөрдөж болно.</p> <p><b>2-рт Туршилтын аргаар</b> үндсэн нормыг тооцох: Туршилт хийсэн хугацаа 6 дугаар сарын 5-7-ны өдрүүд Туршилт хийсэн байршил: Улаанбаатар хотод Туршилт явуулсан аргачлал: Уг автомашины хоногийн</p>



			<p>дундаж гүйлт L=60 км, Н<sub>жишиг</sub> ≈ 6,5 л гэсэн бэлэн өгөгдлийг туршилт явуулах аргачлалд ашиглав.</p> <p>Автомашины бакыг султган 10 л шатахуунаар өдөр бүр цэнэглэн өдрийн ажилд гарган ажлаас буухад явсан гүйлт, үлдэгдэл шатахууныг хэмжин бүртгэх байдлаар судалгааг хийв.</p> <p>Судалгааны өгөгдлийг ашиглан 100 км гүйлт дэх бодит гүйлтийг тооцвол / Энэ тохиолдолд хөдөлгөөний эрчимийн нэмэгдлийг хасаж тооцоход:</p> <p>1 дэхь өдөр Н<sub>бодит</sub>= 7.15  2 дахь өдөр Н<sub>бодит</sub>= 7,56  3 дахь өдөр Н<sub>бодит</sub>= 7,3  байв.</p> <p>Иймд Toyota ractis автомашины үндсэн нормыг Н<sub>v</sub>≈ 7,5 тогтоож болно.</p> <p>Хэмжилт туршилтын аргаар шатахуун зарцуулалтыг тогтооход автомашины техникийн байдлыг хэвийн эсэхийг шалгах, туршилтын хугацаанд техникийн байдал, жолоочийн ур чадвар шатахуун зарцуулалтад нөлөөлөх эсэхийг хянах, хэмжилтийг үнэн зөв нарийвчлалтай авах, туршилтын арга нь техникийн байдалд нөлөөлөхгүй аргыг сонгох зэрэг мэргэжлийн дадлага туршлага бүхий инженер, техникийн ажилтан туршилт, хэмжилтийг явуулах зайлшгүй шаардлагтай юм. Тухайлбал, дээрх туршилтын арга буюу бакыг султган шатахуунаар цэнэглэн туршилт явуулахад тушилт явуулах гүйлтийг сайтар тооцохгүй бол бензин насос хий сорох, улмаар техникийн байдалд муугаар нөлөөлөх талтай юм.</p>
3	<b>АВТОМАШИНЫ ШАТАХУУН ЗАРЦУУЛАЛТЫН НЭМЭГДЭЛ ТООЦОХ</b>		
3.1	<p>Автозамын нөхцөлөөс хамрааруулж, шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах хувь хэмжээ /Автозамын нөхцлийг тооцох дундаж коэффициент/</p>	$K_3 = \frac{\pm\Pi}{100\%}$ <p>Энд:  П-Автозамын нөхцлөөр шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх буюу хорогдуулах хувь, хорогдуулах тохиолдолд хасах утгыг хэрэглэнэ.</p> $K_3 = \frac{\sum_{i=1}^n SiKi}{\sum_{i=1}^n Si}$ <p>Энд:  К- бүс тус бүрийн автозамын нөхцлийн коэффициент  S- бүс тус бүрт автомашины явсан гүйлт, км  n- тооцоонд орсон бүсийн тоо</p>	<p>Автозамын хучилтын байдал, хөрсний бүтэц, нэг хавтгай дөрвөлжин км, талбайд ногдох бартааг гол үзүүлэлт болгон тус орны нутаг дэвсгэрийг автозамын нөхцөлөөр 5 бүсэд хувааж бүсийн хилийг сумдын хилээр тогтоож автозамын ашиглалтын нөхцлөөр шатахуун зарцуулалтыг нэмэгдүүлэх буюу хорогдуулах коэффициентийг тогтоож 1 хавсралтын Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүдийн 1-д тусгасан.</p> <p>Автозамын өнөршилт, далайн түвшинөөс дээш 1000-1500 метрт орших, харьцангуй бага бартаатай нутгийн хөрсөн замд шатахууны үндсэн нормыг нэмэгдүүлэхгүй ба хорогдуулахгүй, харин өндөршил адил боловч нэг хавтгай дөрвөлжин км талбайд ногдох бартаа ихтэй нутагт ажиллах автомашины шатахууны үндсэн нормыг 5%, далайн түвшинөөс дээш 1500-2000 метрт орших нутагт 10%, далайн түвшинөөс дээш 2000 метрээс дээш орших ба элсэрхэг хөрстэй нутагт 15%-иар тус тус нэмэгдүүлж тооцно.</p> <p>Мөн автомашины шатахууны үндсэн нормыг далайн түвшинөөс 500-1000 метрт өргөгдсөн Дорнод, Сүхбаатар аймгийн бүх нутагт 5%-иар хорогдуулан тооцно.</p> <p>Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг автозамын нөхцөлөөс хамааруулж нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүдийг коэффициентэд шилжүүлбэл,  I бүс П=+15</p> $K_3 = \frac{\pm\Pi}{100\%} = \frac{+15}{00\%} = 0.15 \text{ байна}$ <p>Дээрх жишээнд Toyota ractis автомашины үндсэн нормыг Н<sub>v</sub>≈7.5 гэж тогтоосон. Уг автомашин Архангай аймгийн Тариат суманд 1 сарын хугацаагаар ажиллах</p>

			<p>тохиолдолд 100 км-т олговол зохих шатахууныг тооцвол:</p> <p>Архангай аймгийн Тариат сум нь Автозамын нөхцөлөөс хамааруулж шатахуун зарцуулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийн I бүсэд хамаарах бөгөөд шатахуун зарцуулалтыг 15%-иар нэмэгдүүлэн тооцно гэж заасан байна.</p> $H_3 = H_v \times (1 + K_3) = 7.5 \text{ л} \times 1.15 = 8.6 \text{ л} / 100 \text{ км}$
3.2	Хүйтний улиралд олгох шатахууны нэмэгдэл	$K_x = \frac{\pm \Pi}{100\%}$ <p>Энд: Π-хүйтний улирлын нэмэгдлийн хэмжээ, %</p>	<p>Тус орны нутаг дэвсгэрийг хүйтний 3 бүсэд хуваан, бүсийн хилийг сумдын хилээр тогтоож, түүнд харьяалагдах аймаг, сум олгох нэмэгдлийн хэмжээг 1 дүгээр хавсралтын Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүдийн 2-т үзүүлэв. Энэхүү шатахууны нэмэгдлийг зөвхөн тэр бүсэд ажилласан автомашинд олгох бөгөөд тухайн хүйтний бүсийг дамжин өнгөрвөл аль бүсээр явсныг харгалзахгүйгээр 10 дугаар сарын 15-наас 4 дүгээр сарын 11-нийг хүртэл хугацаанд 20% хувиар нэмэгдэл тооцож олгоно.</p> <p>Дээрх жишээ бодлого дээр уг автомашин 3 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл 1 сарын хугацаагаар гэсэн өгөгдлийг нэмэж шатахуун зарцуулалтыг тооцвол: Toyota ractis автомашин автозамын нэмэгдэл тооцсон <math>H_3 = 8.6 \text{ л} / 100 \text{ км}</math> тооцно.</p> <p>Архангай аймгийн тариат сум нь “Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хүйтний улиралд нэмэгдүүлэх хувь хэмжээ, мөрдөх хугацаа”-ны II бүсэд хамаарах, 3 дугаар сарын 1-нээс 4 сарын 1 хүртэл хугацаа нь хүйтний нэмэгдэл олгох хугацаанд багтаж байгаа бөгөөд шатахуун зарцуулалтыг 20%-иар нэмэгдүүлэн тооцохоор заасан байна.</p> <p>Иймд <math>H_x = H_3 \times (1 + K_x) = 8.6 \times 1.2 = 10.3 \text{ л} / 100 \text{ км}</math> болно.</p>
3.3	Ажил үйлчилгээний онцлог, автозамын онцгой хүнд нөхцлийн нэмэгдэл	$K_T = \frac{\pm \Pi}{100\%}$ <p>Энд: Π-тусгай нэмэгдлийн хэмжээ, %</p>	<p>Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нэмэгдлийн хэмжээ, олгох нөхцлийг 1 дүгээр хавсралтын Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүдийн 3-т үзүүлэв. Тухайлбал, Улаанбаатар хотын хөдөлгөөний эрчим, ажил үйлчилгээний онцлог, тээвэрлэлтийн тусгай нөхцөлийг тусгасан шатахуун зарцуулалтын нэмэгдлүүд багтсан.</p> <p>Улаанбаатар хотод ажиллах автомашины шатахуун зарцуулалтын нэмэгдлийг тооцвол: Toyota ractis автомашины үндсэн норм <math>H_v \approx 7.5 \text{ л}</math> Улаанбаатар хотын автозамын хөдөлгөөний эрчимийг тооцсон шатахуун зарцуулалтын нормын нэмэгдэл- 20%</p> $K_3 = \frac{\pm \Pi}{100\%} = \frac{20}{100\%} = 0.2$ $H_3 = H_v \times (1 + K_3) = 7.5 \times 1.2 = 9.0 \text{ л}$
3.4	Автомашины 100 ткм тээврийн ажлын болон өөрөө буулгагч автомашины ачаагаа буулгахад зарцуулах	$H_w = H_{\text{тн,км}} \times \frac{W}{100}$ <p>Энд: <math>H_w</math> – автомашины тнкм-ийн ажилд олговол зохих шатахууны нэмэгдэл <math>H_{\text{тн,км}}</math> автомашины хөдөлгүүрээс</p>	<p>Автомашины 100 ткм тээврийн ажлын болон өөрөө буулгагч автомашины ачаагаа буулгахад зарцуулах шатахууны нормыг 1 дүгээр хавсралтын Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүдийн 4-т үзүүлэв.</p> <p>Автомашины 100 ткм тээврийн ажлын шатахууны нэмэгдлийг тооцохын тулд тухайн ачааны автомашины бүтээлийг тооцох шаардлагтай.</p>

	<p>шатахууны норм</p>	<p>хамааруулан 100 ткм тээврийн ажилд олговол зохих шатахууны хэмжээ  W- автомашины хийсэн ажлын хэмжээ буюу бүтээл</p> $W = G \times S$ <p>Энд:</p> <p>W – автомашины бүтээл, ткм  G – ачааны хэмжээ, тн  S- гүйлт, км</p>	<p>Hino ZY200 маркийн өөрөө буулгагч автомашин 150 км гүйлтэд 8 тн ачаатай нийт 3 удаа рейс хийв.</p> $W=450\text{км} \times 8\text{тн} = 3600\text{тн,км}$ $H_{\text{тн,км}} = 1,725 \text{ л /Дизел хөдөлгүүр бүхий автомашин 100 тнкм тутамд 1,725 л гэж заасан байна/}$ $H_w = H_{\text{тн,км}} \times \frac{W}{100} = 1,725 \times \frac{3600}{100} = 62.1 \text{ л}$ <p>Өөрөө буулгагч автомашин 3 удаагийн рейсэнд 2 талдаа ачаатай 6 удаа ачаагаа буулгасан, 6-20 тн даацтай автомашин ачаагаа буулгахад төхөөрөмж ажиллуулах бүрт 0,5 л шатахуун олгон гэж үзвэл:</p> $H_r = H_{\text{өг}} \times n = 0.5\text{л} \times 6 = 3\text{л}$ <p>ачаатай гүйлт, өөрөө буулгагч төхөөрөмжөө ажиллуулахад зарцуулах шатахуун нэмэгдэл 65,1 л-ийг олгохоор байна.</p>
--	-----------------------	---	---

**АВТОМАШИНЫ ЭДЭЛГЭЭНИЙ НӨӨЦИЙН  
ДООД ХЯЗГААРЫН ЖИШИГ НОРМ**

№	Автомашины марк, загвар	Эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм /мян.км/			
		Суудлын автомашин		Ачааны автомашин	Автобус
		ердийн	жип		
1	AUDI	350-450	-	-	-
2	BMW	400-500	-	-	-
3	CADILLAC	450	400	-	-
4	CHEVROLET	400	350	-	-
5	DAEWOO	300-350	400-450	-	-
6	FORD	300-350	500-550	-	400
7	GAZ	250-350	250	350	350
8	HINO	-	-	450	-
9	HONDA	300-350	350	-	-
10	HUMMER				
11	HYUNDAI	300-350	350-400	350	350
12	INFINITI				
13	ISUZU	-	350-400	350	-
14	JEEP	-	450-500	-	-
15	KIA	300	375	400	350
16	LANDROVER	-	450	-	-
17	LEXUS	500	-	-	-
18	MAZDA	350	-	-	-
19	MERCEDES BENZ	400-500	450-500	500	400
20	MITSUBISHI	350-400	400-450	350	350-400
21	NISSAN	350-400	400-450	400	350
22	PAZ	-	-	-	280
23	SKODA	325-350	-	-	-
24	SSANGYONG				
25	SUBARU	300-350	-	-	-
26	SUZUKI	300-350	350	-	-
27	TOYOTA	350-400	450-550		400
28	UAZ	250-300	350-400	350-400	300-350
29	VOLKSWAGEN	300-350	-	-	350
30	VOLVO	350-400	-	-	-

## **АВТОМАШИНЫ ЭДЭЛГЭЭНИЙ НӨӨЦИЙН ДООД ХЯЗГААР, ГҮЙЛТИЙН НОРМЫГ ТОГТООХОД ХАРГАЛЗАХ НӨХЦӨЛҮҮД**

1. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины нөөцийн доод хязгаарын жишиг нормыг үйлдвэрлэгч болон судалгааны үндсэн дээр тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаартай харьцуулан гүйлтийн нормыг өөрсдөө тогтоож мөрдөнө.
2. Аж ахуйн нэгж, байгууллага нь автомашины эдэлгээний гүйлтийн нормыг тогтоохдоо ашиглалтын бүс, тээвэрлэлтийн нөхцөл, ачааллаас хамааруулан доорх хувиар хорогдуулан тооцож болно.

2.1. Автозамын нөхцөлөөс хамааруулж автомашины эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь хэмжээ:

№	Автозамын нөхцөл	Бууруулах хувь хэмжээ
1	Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Завхан, Ховд, Говь-Алтай аймгийн нутагт ердийн хөрсөн замд ажилладаг автомашин	10,0
2	Өмнөговь, Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн нутагт ердийн хөрсөн замд ажилладаг автомашин	5,0
3	Ашиглалтын хүнд нөхцөлд (уулнаас мод цагаалах, тариан талбайд ажиллах, замгүй газраар хайгуулын ажилд явах, уул уурхайн карьерт ажиллах )	15,0

2.2. Автомашины төрөл ачааллаас хамааруулж автомашины эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь хэмжээ:

№	Автомашины төрөл, ачаалал	Бууруулах хувь хэмжээ
1	Хоёр голт чиргүүлтэй ажиллавал	15,0
2	Хоёр голт, хоёр чиргүүлтэй ажиллавал	25,0
3	Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээний зориулалтын автомашин	25,0
4	Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашин	20,0



	арьс хөндлөвч											
-	Хойд хөтлөгч тэнхлэг, ерөнхий дамжуулга, арьс, их бие	250	300	250	250	300	300	250	300	200	-	-
-	Дефференциалын аяга, чагт	150	250	150	250	300	300	200	250	200	-	-
-	Хагас гол, дугуйн бул	60	80	80	150	200	300	100	150	150	-	-
-	Тоормозны хурд, диск тэлэгчүүд	60	80	60	60	60	60	60	80	80	-	-
-	Кардан дамжуулга	60	80	80	80	150	200	100	150	150	-	-
-	Пүрш, нум, амортизатор	60	70	60	60	80	200	100	100	150	-	-
<b>4</b>	<b>Жолооны удирдлага</b>											
-	Жолооны гол	125	150	125	150	200	250	100	150	150	200	250
-	Хорхой араа ба хэдрэг	80	100	125	150	200	250	100	125	150	200	250
-	Жолооны хүчлүүр	80	150	80	150	200	200	150	200	200	250	250
-	Хөндлөн дагуу татуургууд	60	80	80	100	150	200	60	80	80	150	200
-	Өндгөн тулгуур бөмбөлгөн хуруу	80	120	80	100	150	200	80	100	80	150	200
<b>5</b>	<b>Ачааны автомашины кабин, суудлын автомашин, автобусны кузов</b>											
-	Нүүр, крыло	250	300	250	250	300	600	150	200	300	350	400
-	Хаалга	200	250	250	250	300	400	200	200	300	350	400
-	Тэвшний хөндлөвч гуя, шал	-	-	-	-	-	-	150	150	200	250	300
-	Багажны таг	250	300	-	-	-	-	-	-	-	-	-
-	Суурь шал, хөндөл	-	-	250	300	400	300	-	-	-	-	-
-	Арлын дагуу гуя	-	-	250	300	250	300	150	200	250	250	400

Тайлбар: Автомашины үндсэн агрегат зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормыг аж ахуйн нэгж байгууллага, иргэд шууд үндсэн норм хэлбэрээр түр ба урт хугацаагаар хэрэглэж болохын зэрэгцээ тодорхой хугацаанд жишиг нормын мөрдөлтөд хэмжилт, судалгаа явуулсны үндсэн дээр өөрийн ажил үйлчилгээ, ашиглалтын нөхцөл байдалд нийцүүлэн нэмэгдүүлэх буюу хорогдуулах замаар дотоодын норм тогтоож болно.

Тээврийн хэрэгсэлд хуучин сэлбэг тавих тохиолдолд техникийн байдал, элэгдэлийг тогтоосны үндсэн дээр үлдсэн эдэлгээний нөөцийг тооцно.







120	265/75													
121	265/80													
122	265/85													
123	275/70													
124	275/75													
125	275/80													
<b>R17</b>														
126	225/55													
127	225/60													
128	225/65													
129	235/50													
130	235/55													
131	235/60													
132	235/65													
133	245/45													
134	245/50													
135	245/55													
136	245/60													
137	255/50													
138	255/55	80.0	80.0	80.0	80.0	80.0	75.0	75.0	75.0	75.0	-	-	-	-
139	255/60													
140	255/65													
141	255/70													
142	265/50													
143	265/55													
144	265/60													
145	265/65													
146	265/70													
147	275/55													
148	275/60													
149	275/65													
150	275/70													
<b>АЧААНЫ АВТОМАШИН БОЛОН АВТОБУС</b>														
151	145/80 R12 (6PR, 8PR)	35.0	35.0	35.0	35.0	35.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	-	-	30.0
152	145/SR 12 (6PR, 8PR)	38.0	37.0	35.0	35.0	35.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	-	-	30.0
153	6.45 R13	50.0	50.0	45.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0	40.0	40.0
154	8.40 R15	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
155	8.40 R20	50.0	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0	40.0
156	9.00 R20	50.0	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0	40.0
157	10.00 R20	60.0	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0	50.0
158	11.00 R20	60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0	50.0	50.0	50.0	50.0
159	12.00 R20	50.0	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0	40.0
160	14.00 R20	50.0	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0	40.0
161	12.00 R18	50.0	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0	40.0
162	13.00 R18	50.0	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0	40.0
163	12.00 R22.5	70.0	70.0	70.0	70.0	65.0	65.0	65.0	65.0	60.0	60.0	60.0	60.0	60.0
164	335/80 R20	60.0	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0	50.0

### 3. РЕЗИН ДУГУЙН ГҮЙЛТИЙН НОРМЫГ ТОГТООХОД ХАРГАЛЗАХ НӨХЦӨЛҮҮД

1. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг үйлдвэрлэгчээс тогтоосон резин дугуйн доод хязгаар буюу гүйлтийн нормтой харьцуулан өөрсдөө тогтоож мөрдөнө.
2. Резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг уур амьсгал, авто замын нөхцлийг харгалзан тогтоосон ашиглалтын бүсээс хамааруулан резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг доорх хувиар хорогдуулан тооцож болно.

Бүсийн дугаар	Тухайн бүсэд багтах аймгууд	Эдэлгээний нөөцийн доод хязгаарыг хорогдуулах хувь
I бүс	Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул, Төв, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод, Хэнтий	-
II бүс	Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл /ердийн хөрсөн замд/	10,0

3. Мод бэлтгэх карьерын нөхцөл нь ашиглалтын бүсийн ялгаанаас хамаарахгүйгээр хоёр бүсэд аль алинд нь ижил байх учир энэ нөхцөлд резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормын тооцоонд ашиглалтын бүсийн хорогдуулах хувийг хэрэглэхгүй.
4. Автомашины тээвэрлэлтийн нөхцлийг харгалзан резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг доорх хувиар бууруулан хэрэглэж болно.

№	Автомашины тээвэрлэлтийн нөхцөл	Эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь
1	Байнга нэг чиргүүлтэй ажилладаг ачааны автомашинд	15,0
2	Мод бэлтгэл, уул уурхайн карьерын нөхцөлд тогтмол ажилладаг ачааны автомашинд	30,0
3	Байнга 2 чиргүүлтэй буюу 10 тн-оос дээш даацтай, олон голт чиргүүл /трейллер/ чирдэг автомашинд	25,0
4	Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашинд /ердийн хөрсөн зам болон автозамын онцгой хүнд нөхцөлд/	25,0

5. Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашины резин дугуйн гүйлтийн нормд автозамын онцгой хүнд нөхцөлийг тооцсон тул II бүсэд хамаарах бүсийн хорогдуулах хувийг хэрэглэхгүй.

#### 4. ЗАЙ ХУРААГУУРЫН ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦААНЫ ДООД ХЯЗГААРЫН ЖИШИГ НОРМ

1. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь зай хураагуурын үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний хугацааны доод хязгаарыг үндэслэн зай хураагуурын үндсэн нормыг тогтоож мөрдөнө.
2. Ашиглалтын хугацаанд автомашины нэмэгдэл төхөөрөмж хөдөлгүүр унтраасан үед зай хураагуураас тэжээл авч ажиллах нөхцөлд нэмэгдэл төхөөрөмжийн /JPS, дохиолол, тог хувиргагч гэх мэт/ тооноос хамааруулан зай хураагуурын эдэлгээний нормыг 50 хүртэл хувиар бууруулан тооцож болно

№	Зай хураагуурын багтаамж, ампер-цаг	Автомашины төрөл
1	50-80 хүртэл	суудлын автомашин, бага даацын ачааны автомашин, бага багтаамжийн автобусанд
2	90-100 хүртэл	ачааны автомашин, дунд багтаамжийн автобусанд
3	130-200 хүртэл	их даацын ачааны автомашин, их багтаамжийн автобусанд